



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТР

ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ (Үндэсний бөх)

УЛСЫН ХАРЦАГА Ц.МӨНХБАЯР, АЙМГИЙН АРСЛАН Б.ӨСӨХБАЯР НАРТ
ШИЙТГЭЛИЙГ ОНОГДУУЛАХДАА ДОПИНГИЙН ЭСРЭГ ДҮРЭМ ЗӨРЧСӨН
БОЛОХЫГ ТОГТООЛОО.

Монголын үндэсний бөхийн спортоор хичээллэж буй тамирчид болох Улсын харцага Ц.Мөнхбаяр, Аймгийн арслан Б.Өсөхбаяр нар нь Монголын Үндэсний бөхийн холбоо ТББ-ийн Тэргүүлэгчдийн 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн №69 дугаартай шийдвэрийг гаргахдаа Допингийн эсрэг дүрэм, Үр дүнгийн удирдлагын олон улсын стандартыг зөрчсөн болохыг тогтоож, өөрт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах, барилдах эрхийг сэргээхийг Монголын Үндэсний бөхийн холбоо НҮТББ-д даалгах шаардлага бүхий өргөдлийг 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр гаргасан. Тодоруулбал Монголын Үндэсний бөхийн холбоо ТББ-ийн Тэргүүлэгчдийн шийдвэр гаргахдаа Допингийн эсрэг дүрэм болон холбогдох бусад олон улсын стандартуудад нийцсэн эсэхийг тогтоолгохыг хүссэн бөгөөд допинг илэрсэн, илрээгүй талаарх нэхэмжлэлийн шаардлага гаргаагүй, бөхчүүдийн хэн аль нь допинг илэрсэн асуудалд маргадаггүй.

Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын дэргэдэх допингийн Давж заалдах комиссын хуралдаан болж 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 23/120 дугаар шийдвэрээр Улсын харцага Ц.Мөнхбаяр, Аймгийн арслан Б.Өсөхбаяр нарт шийтгэлийг оногдуулахдаа допингийн эсрэг дүрэм, олон улсын стандартуудыг зөрчсөн болохыг тогтоосон. Харин барилдах эрхийг сэргээхийг Монголын Үндэсний бөхийн холбоо ТББ-д даалгах хэсгийг хангаагүй шийдвэрлэсэн болно.

Давж заалдах комисс нь допинг хэрэглэсэн эсэхэд огт үнэлэлт, дүгнэлт гаргаагүй бөгөөд Монголын Үндэсний бөхийн холбоо ТББ нь допингийн эсрэг дүрмийн зөрчил гаргасан эсэхэд дүгнэлт гаргасан болно. Давж заалдах комисс нь зөвхөн нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд хэрэг, маргааныг шийдвэрлэх бөгөөд допингийн эсрэг дүрмийн зөрчлийг шалган тогтоох эрх олгогдсон байгууллага болно.

Тухайлбал, допингийн дүрэмд заасны дагуу үр дүнгийн удирдлагыг хэрэгжүүлсэн этгээдийн дүрмийн зөрчлийг шалган тогтоож дүгнэлт гаргасан бөгөөд энэ нь допинг хэрэглэсэн үйлдлийг зөвтгөсөн эсхүл хариуцлагаас чөлөөлсөн шийдвэр биш болохыг мэдээлж байна.

МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТРЫН ДЭРГЭДЭХ
ДОПИНГИЙН ДАВЖ ЗААЛДАХ КОМИСС

2024.02.06